



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар А/130

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн хөгжлийн яамны 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 03/5454 тоот албан бичгийн дагуу ИНЕГ/ТББ/Б-01/11 дүгээр гэрээг дуусгавар болгосонтой холбогдуулан гүйцэтгэгчийн нийлүүлсэн тоног төхөөрөмжийг төслийн зориулалтын дагуу Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгийн нисэх буудлын гэрэл суултын системийн битүүмжилсэн эд ангийг тулган хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгийн нисэх буудлын гэрэл суултын системийн битүүмжилсэн эд ангийг тулган хүлээн авах ажлыг 2018 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор дуусгаж Иргэний нисэхийн ерөнхий газрын даргад тайлагнахыг Ажлын хэсгийн дарга /А.Амгалан, Х.Баттулга/ нарт даалгасугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигацийн бодлого, зохицуулалтын хэлтэс /Ё.Эрдэнэбат/, Нисэх буудлуудын бодлого, зохицуулалтын хэлтэс /Д.Эрдэнэбаатар/, Санхүү, эдийн засгийн хэлтэс /Ч.Нямсүрэн/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Л.БЯМБАСҮРЭН

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2018 оны 23 дугаар сарын 17 ны өдрийн
8/30 дугаар тушаалын хавсралт



Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгийн нисэх буудлын гэрэл суултын системийн битүүмжилсэн эд ангийг тулган хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

1. Говь-Алтай аймгийн нисэх буудалд ажиллах ажлын хэсэг:

| | | |
|-----------------------|---------------|---|
| Ажлын хэсгийн дарга: | А.Амгалан | Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны Гэрэл суултын тасгийн ахлагч инженер |
| Нарийн бичгийн дарга: | Б.Санчир | Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн |
| Гишүүд: | Д.Батбаяр | Говь-Алтай аймгийн нисэх буудлын дарга |
| | Ц.Дөлгөөн | Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны нягтлан бодогч |
| | Г.Даваадулам | Говь-Алтай аймгийн нисэх буудлын нягтлан бодогч |
| | Б.Нандинцэцэг | Говь-Алтай аймгийн нисэх буудлын холбооны инженер |

2. Завхан аймгийн нисэх буудалд ажиллах ажлын хэсэг:

| | | |
|-----------------------|---------------|---|
| Ажлын хэсгийн дарга: | А.Амгалан | Техник хангалт, навигацийн үйлчилгээний албаны Гэрэл суултын тасгийн ахлагч инженер |
| Нарийн бичгийн дарга: | Б.Санчир | Худалдан авах ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн |
| Гишүүд: | Ж.Бяхаржалбуу | Завхан аймгийн нисэх буудлын дарга |
| | Ц.Дөлгөөн | Үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэлийн албаны нягтлан бодогч |
| | Г.Алтанцэцэг | Завхан аймгийн нисэх буудлын нягтлан бодогч |

